

МОНГОЛ-ОРОСЫН 1912 ОНЫ НАЙРАМДЛЫН ГЭРЭЭ БА И.Я.КОРОСТОВЕЦ

О.Батсайхан*

1912 оны 11 дүгээр сарын 3-нд байгуулсан Монгол Оросын Найрамдлын гэрээний чухам үнэн байдлыг тодруулж, уг гэрээний учир холбогдол, Монголын түүхэнд оруулсан түүхэн үүрэг, эл гэрээ байгуулахад Оросын Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч И.Я.Коростовецийн үүрэг хэр байсан талаар тодруулахад энэхүү өгүүллийн зорилго оршино.

Монголчууд 1911 онд тусгаар тогтнолоо тунхаглан зарласан 1911 оны зун байгуулагдсан Түр Засгийн газраас Монголыг тусгаар болгож, төр засгийг төвхнүүлэх ажлын хүрээнд Монгол улсын хаан ширээнд Богд гэгээн Жавзандамбыг залж, суулгах их ёслол хийх өдрийг бүх Монгол даяар зарласнаас гадна Хүрээнд суугаа Орос улсын консулд албан ёсоор мэдэгджээ. 1911 оны өвлийн тэргүүн сард Түр засгийн газраас Их Орос улсын ерөнхий консулд явуулсан бичигт: «энэ жил зуны цаг манай Халхын дөрвөн аймгийн хан ван, гүн, олон засгууд шарын шашныг өрнөөн дэлгэрүүлэх ба улс төрөө бататгахыг бүгдээр санаа нийлж, зөвлөлдөн Богд гэгээнийг Монгол улсын хаанд өргөмжилж эрдэнийн сууринд залж ёслол мөргөж, их төрийн ёслолыг гүйцэтгэх өдрийг энэ цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9-ний барс цагт тогтоосон учрыг Оросын эзэн хааны засгийн газар уламжилна уу» хэмээжээ.¹

Монголчууд сайн өдрийг сонгон хүлээж, Монголын төрөө тунхаглан зарлахад хэн хүнгүй бэлдэлгээсэн байна. Холынхоос нь хэмээвэл, “Халхын өмнө, умар хязгаарын ойр зэрэгцэн суусан Дариганга, Хөвсгөл нуурын Урианхайн бүгдийн дарга Сономдовдон, Хишигжаргал нараас тус тусын Богдын лүндэн зарлигийг чин үнэнхүүгээр итгэн биширч соёлд багтахыг харьяа ардуудлаа зарлаад өршөөлийн дотор агуулах явдлыг хичээнгүйлэн гуйсугай”² хэмээсэн бичгийг Хүрээний хэргийг шийтгэх газарт ирүүлсэн байв

Халхын дөрвөн аймгийн хан, чуулганы дарга, жанжин, дэд чуулганы дарга, хэбэй, олон засаг ван, гүн, хутагт, хувилгаад, тайж түшмэд ардуудын төлөөлөгчид Хүрээнд цугларан “Монголын төрийн орд, Дотоод, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх таван яамны байгуулалтыг урьдаар засаггаан бэлтгэхэд төв гэрүүдийг цөм монгол гэр үйлдэн”³ бэлджээ.

Ийнхүү товлосон ёсоор Монголын цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9 бөгөөд европ тооллын 1911 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн 12 цагт Монгол улсын хаан ширээнд Богд Жавзандамба хутагтыг өргөмжилснөөр төрийн их ёслол эхэлж байжээ. Мөн Богдын хатан, эрдэнэ сэцэн Цагаан Дара Дондогдуламыг улсын эхэд өргөмжилсөн байна.⁴

* О.Батсайхан – ОУСХ-гийн Орос судлалын секторын эрхлэгч, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Энэ бол Монгол улс Манжаас салж тусгаар улс болсноо тунхаглан зарласны илэрхийлэл байлаа.

Найрамдлын гэрээ байгуулахын өмнөхөн үе

Дөнгөж тусгаар тогтносон Монголд өөрийн хувь заяаг Орос оронтой холбох үндэслэл байсан бол Орос орон ч гэсэн Монголыг гойд сонирхох хангалттай үндэслэл байсан юм хэмээн И.Майский 1921 онд бичжээ.

Тухайлбал Монгол орон Орост юугаар хэрэгтэй байсан талаар хоёр зүйлийг хэлж болох юм, нэгдүгээрт, эдийн засгийн хувьд, Монгол орон мал болон мал аж ахуйн түүхийн эд Оросын зах зээлд нийлүүлэгч байхаас гадна уул уурхай байгалийн баялгийн эх сурвалж болж байсан юм. Хоёрдугаарт, Монгол орон Оросын хувьд улс төрийн онцгой ач холбогдолтой байсан. Хятад энэ үед дотоодлоо хагаралтай байж, европийн соёлд дасан зохицох гэж зовж байгаа билээ. Дээр дурьдсан зүйлүүдэд үндэслэн Орос улсаас Монголын талаар баримтлах ерөнхий чиг шугамыг харж болох бөгөөд тэр нь Орос орны хувьд Монголын төрийн тусгаар тогтнолыг тодорхой хэмжээгээр хадгалах нь онцгой чухал байсан, Монгол орныг буфер маягаар барьж байх сонирхол Оросын төрд байсан хэмээн Майский үзэж байжээ.⁵

Хятадын эрхтэнүүд Оросын элчингийн хооронд монголын асуудлаар маргаан болж байх завсар Бээжин дэх Оросын элчингийн дэвшүүлсэн саналыг Оросын Гадаад явдлын яам нааштай хүлээн авч, Орос Халхын хооронд байгуулж болох хэлэлцээрийн төслийг боловсруулан Засгийн газраараа хэлэлцэж, эзэн хаан хоёрдугаар Николайд танилцуулахад «Яаравчлах хэрэгтэй» хэмээн тэрээр цохжээ. Эзэн хааныхаа өгсөн зааврын дагуу Оросын Сайд нарын Зөвлөлийн тусгай хуралдаанаар 1912 оны 8 дугаар сарын 2-ны өдөр уг асуудлыг хэлэлцэж, Гадаад явдлын яамны сайдын саналаар Монголын асуудлаар Хятадтай явуулж буй хэлэлцээг тасалж, Хүрээтэй нууц хэлэлцээг эхлэх шийдвэр гаргажээ.⁶ Орос улсын Сайд нарын Зөвлөл 1912 оны 8 дугаар сарын 2-ны хуралдаанаар Монголтой байгуулах гэрээний асуудлыг «Хүрээний хутагт ба халхын ноёдтой байгуулах гэрээний тухай» гэсэн нэрийн дор авч хэлэлцэн гаргасан шийдвэртэй «Монголын асуудлаар азнах явдал улам бүр осолтой болсоор» байна гээд энэ байдлаас гарах «сайн арга шийдвэр гэвэл Орос, Халхын хооронд дипломат гэрээ байгуулах явдал мөн гэж» заасан байна. Бэлтгэж байгаа гэрээг Монгол улстай байгуулах гэрээ хэмээн нэрлэхгүйгээр зөвхөн «Хүрээний хутагт ба халхын ноёдтой байгуулах гэрээ» гэж томъёолохын хамт гэрээгээр Монголын тунхаглан зарласан тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч бататгах бус тодорхойгүй, бүрхэгдүүхэн «Халхын ёс журам» гэдгийг хадгалан байлгахыг Орос улс амлах, «Дотоод Монгол ба Баргаас Хүрээний засгийн газарт дагаар орох тухай зарлан тунхагласан зарим зүйлийг одоохондоо уг хэлэлцээрийн гадна орших» зэрэг үндэслэлүүдийг баримтлах чиглэлийг уг шийдвэрт тусгасан байна.⁷

Энэхүү шийдвэр нь Монголын тусгаар тогтнолыг шууд хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийсэн өнгө аястай боловч гэрээ байгуулах субъект нь «Орос ба Монгол» гэсэн хоёр этгээд байх бөгөөд хэлэлцээнээс гарах баримт

бичиг нь олон улсын хууль зүйн хэм хэмжээнд ямар нэгэн байдлаар нийцсэн дипломат гэрээ байх нь магад тул Монголын хувьд олон улсын харилцааны талбарт гарах чухал ач холбогдолтой байх нь эргэлзээгүй хэрэг байлаа. Мэдээж Оросын эзэнт улс өөрийн ашиг сонирхлын асуудлыг урьдач болгож байсан хэдий ч монголчуудын хувьд ийм замыг сонгох нь ашигтай байлаа. Үүнийг Монголын төрийн зүтгэлтнүүд сайтар ухаарч байсан юм. Орос улсын төрийн зүтгэлтнүүд, Гадаад яамны сайд Монголтой шууд харилцаж, хоёр орны хооронд хэлэлцээр байгуулах асуудлыг түргэвчилж эхэллээ.

Орос улс Монголтой шууд хэлэлцээр хийхээр нэгэнт шийдсэн тул даруй ажилдаа орж, энэ хэлэлцээг явуулах тусгай төлөөлөгчөөр туршлагатай дипломатч И.Я.Коростовецийг томилсон тухайгаа 1912 оны 8 дугаар сард Монголын Засгийн газарт мэдэгдсэн байна. Монгол улсын Эзэн хаан Богд Жавзандамба хутагт тэргүүтэй Засгийн газар хоёр улсын хооронд Найрамдлын гэрээ байгуулах тухай умард хөршийн саналыг таатай хүлээн авч, эл хэлэлцээрийг явуулахаар тусгай элчин сайд Коростовецийг илгээсэнд Орос улсын хаан эзэнд талархаж буйгаа илэрхийлжээ.⁸

Монголтой гэрээ байгуулах талаар Оросын Засгийн газраас хийсэн дараагийн арга хэмжээ нь Оросын Гадаад явдлын яамнаас 1912 оны 8 дугаар сарын 23-нд Оросын бүрэн эрх барих төлөөлөгч И.Коростовецэд өгсөн заавар байлаа. Тэрхүү зааврын эхэнд: Монголын асуудлаар Орос улс Хятадтай хэлэлцэн тохироход чиглэсэн үйл ажиллагаа «ямар нэгэн мэдэгдэхүйц үр дүнд хүрсэнгүй», энэ нь хятадууд «Монголын тусгаар тогтнолыг хүчээр устгах» зорилгоор «Монголын ноёдын дунд яс хаях», Монголд «цэргийн ангиудыг явуулахаар бэлтгэх» зэрэг үйл ажиллагаатай холбоотой, үүнээс үндэслэн Орос улс Монгол дахь байдал өөрчлөгдсөнийг үл харгалзагч хятадуудтай хэлэлцээ хийж болохгүй боллоо» гэж тэмдэглэжээ.⁹

Цааш нь бичихдээ: Оросын эзэн хааны Засгийн газар Хүрээний Засгийн газартай шууд харилцах замд орж түүнтэй гэрээ байгуулахаар шийдвэрлэлээ гээд Хаант Оросоос Монголд явуулах бодлогыг “манай хязгаартай хил дэрлэх энэ мужид цэргийн хүчтэй улс байгуулахгүй байхыг эрмэлзэх” явдал хэмээн тодорхойлоод “тавьсан зорилгоо хэрэгжүүлэхийн тулд 1.Халхад үндэсний эрхийг олгох, 2.Тэнд хятадын цэргүүдийг оруулахгүй байх, 3.Халхыг хятадуудаар колоничлуулахгүй байх гэсэн гурван нөхцлийг хангахаар төлөвлөж байна”¹⁰ хэмээн мөн заавартаа дурьдсан байна.

Оросын худалдаа- үйлдвэрийн чиглэлийнхэн улс төрийн сонирхлоос илүү эдийн засгийн ашиг сонирхлоо урьтал болгож, Монголын түүхий эдийг дангаар ноёрхох бодлого агуулж байсан бөгөөд үүний улмаас Засгийн газраасаа Монгол дахь оросуудын худалдааны илүү таатай нөхцөл, онцгой эрхийг хуульчилж өгөхийг шаардаж байсан юм. Энэ нь 1912 оны 10 дугаар сард Монгол-Оросын хооронд байгуулсан Найрамдлын гэрээ, 1915 оны Хиагтын гэрээнд тусгалаа олсон гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

1911 оны дараах үеийн Монголын олон улсын байдал

Үнэн хэрэг дээрээ Оросын Монголын талаар баримталж байсан бодлого 1907, 1910, 1912 оны Орос- Японы Алс дорнод дахь нөлөөллийн бүс хуваах тухай нууц хэлэлцээрүүдийн агуулгаар тодорхойлогдож байлаа. 1907 оны 7 дугаар сарын 30-нд байгуулсан Орос Японы улс төрийн гэрээ нь Алс Дорнод дахь их гүрнүүдийн шинэ харьцааг тусгаж, Манжуур, Солонгос, Монголыг нөлөөнийхээ хүрээнд хуваарилсан энэхүү баримт бичиг нь нээлттэй, нууц хоёр хэсгээс бүрдэж байсан бөгөөд нууц хэсгийн 3 дугаар зүйлд: “Гадаад Монгол дахь Оросын тусгай сонирхлыг хүлээн зөвшөөрөхийн хамт эдгээр сонирхолд харшилж болзошгүй оролдлогоос түдгэлзэх үүрэг авсан” байна.¹¹ 1910 онд хоёр этгээд уг гэрээгээ дахин баталсан билээ. 1912 оны 6 дугаар сарын 25-нд мөн асуудлаар Орос Япон хоёр улсын байгуулсан гурав дахь нууц гэрээний 2 дугаар зүйлд заахдаа: “Өвөр Монгол нь Бээжингийн уртраг (Гринвичээс зүүн тийш өргөрөг 116:27)-ийн зүүн баруун хоёр хэсэгт хуваагдана. Оросын эзэн хааны засгийн газар нь дээр дурьдсан уртрагаас зүүн тийш орших Өвөр Монголын хэсэг дэх Японы тусгай ашиг сонирхлыг зөрчихгүй үүргийг хүлээнэ. Японы эзэн хааны засгийн газар нь дурьдсан уртрагаас баруун тийш оршдог Өвөр Монголын хэсэгт Оросын тусгай ашиг сонирхлыг зөрчихгүй үүргийг хүлээнэ” гэсэн байна.¹² 1911 оны 8 дугаар сарын 2-нд А.А.Нератов В.Н.Кокочевт хандан: “Алс дорнодахины манай бодлогын үндэс нь Японтой байгуулсан хэд хэдэн хэлэлцээр болон Манжуур дахь бий болсон үйл ажиллагааны нийтлэг нөхцөл байдлаас үүдэлтэй юм. Алс Дорнод дахь энэхүү амгалан тайван, аюулгүй байдлын гол хүчин зүйлийг эрсдэлд оруулах нь болчимгүй хэрэг болох буй за”¹³ хэмээн бичсэн байдаг. 1912 оны 3 дугаар сард Орос улс Дундад Иргэн улсын засгийн газарт мэдтүгэй хэмээх нот бичиг илгээж: Дундад иргэн улс Хар мөрнөөс цэрэг томилж, Монголд оруулбал Орос улс зүгээр харж суухгүй хэмээн мэдэгдэж байжээ.¹⁴ 1912 оны 10 дугаар сард Монголтой Найрамдлын хэлэлцээр байгуулахдаа ч, 1913 оны 10 дугаар сарын 23 -нд Орос-Хятадын тунхаглалд гарын үсэг зурахдаа ч, 1915 оны Гурван этгээдийн Хиагтын хэлэлцээрийн туршид ч Оросын засгийн газар дээрх байр сууриа тууштай баримталж байв.

Орос Монголын хооронд Найрамдлын гэрээ байгуулсан нь

Харилцан тохирсон ёсоор Оросын Засгийн газрын бүрэн эрх барих төлөөлөгч Иван Коростовец 1912 оны 9 дүгээр сард Нийслэл Хүрээнд хүрэлцэн иржээ. Оросын бүрэн эрх барих төлөөлөгч өөрийн Засгийн газрын шийдвэрийн ёсоор Монгол улсыг автономит улс болгон хүлээн зөвшөөрүүлэх үндсэн санаа бүхий хэлэлцээрийн боловсруулсан төсөлтэй ирж, түүнийгээ Монголын төлөөлөгчид гардуулсан байна. Гэрээний төсөлтэй Монголын төлөөлөгчид танилцаад Монгол улсыг автономит болгох гол санааг үл зөвшөөрч өөрсдийн нэмэлт засварыг оруулсан хариу төслийг санал болгожээ. Монголын төлөөлөгчдийн боловсруулсан Хэлэлцээрийн төслийн үндсэн санаа нь: Нэгэнт

тунхаглан зарласан Монголын тусгаар тогтнолыг хэвээр хадгалан, түүнийг автономн болгон бууруулахгүй байх, Монгол улсад Өвөр Монгол, Баргыг оруулах, Монгол улсын Засгийн газрын төлөөлөгчийг Оросын нийслэлд суулгах зэрэг байлаа. Хэлэлцээр хоёр талын оруулсан төслийг тойруулан нилээд маргаантай болж, гол нь хэлэлцээрийн үндсэн санааг өөр өөрсдийн байр сууринаас хадгалах үүднээс нилээд ширүүн маргаан үүсгэж, заримдаа хэлэлцээ тасарч болох тийм байдалд хүртэл хүрч байжээ. Гэвч хугацаа сунжирч хэлэлцээр тасрах нь монголчуудад ашиггүй байх байсан тул монголын төлөөлөгчид тухайн үед их гүрэнтэй хийж буй чухал хэлэлцээрийн ач холбогдлыг зохих ёсоор тооцон үзэж, Монголын тухайн үеийн дотоод гадаад нөхцөл байдал, энэхүү хэлэлцээрээр олдож болох боломжийг харгалзан цаашид Орос улсад төрийн төлөөлөгчид илгээх, дэлхийн улсуудад хандан дэмжлэг эрэх зэрэг нааштай алхам хийж болох төлөвт найдан зохих буулт хийсэн байна. Оросын төлөөлөгч ч гэсэн зарим зүйл дээр буулт хийж, «Гадаад Монгол» гэсэн томъёоллоос «гадаад» гэсэн үгийг хасч, өргөн утгаар ойлгож болох «Монголия» гэсэн үгийг орос эхэд, «Монгол улс» гэсэн томъёоллыг монгол эхэд хэрэглэхийг зөвшөөрч, бас «автономия» гэсэн грек гаралтай франц үгийг монгол эхэд «өөртөө тогтнож», «өөрөө эзэрхэх» ёс журам хэмээн хөрвүүлэхийг үл татгалзахаар болжээ.

Ийнхүү хоёр талаас буулт хийсний дүнд 1912 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Оросын Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Иван Коростовец Монголын Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн болон түүний Засгийн газрын 5 сайдтай Нийслэл Хүрээнд Найрамдлын гэрээ байгуулан, шинэ тутам байгуулагдсан Монгол улс Орос улсын харилцаа ямар байхыг тодорхойлсон юм.

Гэрээний оршилд монголчууд Монголын нутаг дэвсгэрээс хятадын захиргаа ба цэргийг зайлуулсан, Богд Жавзандамба хутагтыг Монголын ард түмний хаанаар өргөмжилсөн, Монгол Хятадын урьдын харилцаа нэгэнт тасарсан зэрэг байдал болон Орос Монгол хоёр улс эртнээс найрамдалтай байсан хийгээд орос монголын хооронд эдийн засаг, арилжаа өргөжиж, худалдааны журам тогтоох шаардлага гарсан зэргийг харгалзан гэрээ байгуулж буйг дурьджээ. Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд: Оросын эзэн хааны Засгийн газар Монгол улсад «өөрөө тогтнож, өөрөө эзэрхэх» ёс журмаа хадгалан сахих, мөн түүнчлэн «өөрийн нутаг дэвсгэрт хятад цэрэг» ба «нүүдлийн иргэдийг үл оруулан», «өөрийн улсын цэрэг байгуулах» эрхийг эдлэхэд цөм тусална, Харин гэрээний монгол эхэд энд дурьдсан дээр хоёр талын засгийн газрыг харилцан хүлээн зөвшөөрсөн гэсэн санаа туссан байгаа юм. Гэрээний хоёрдугаар зүйлд: Монгол улсын эзэн хаан ба Монгол улсын засгийн газар өөрийн эзэмшил газарт Оросын харьяат нар ба Оросын худалдаанд хэлэлцээрт хавсаргасан Протоколд жагсаан заасан онц эрхийг (эрх ба давуу талыг) хуучин ёсоор олгон хэрэгжүүлнэ. Монголд Оросын харьяат нарт олгосноос илүү эрхийг гадаад бусад орны харьяат нарт үл олгоно. Гуравдугаар зүйлд: хэрэв Монгол улсын засгийн газар хятад ба гадаад бусад улстай тусдаа гэрээ байгуулах хэрэгтэй гэж үзвэл шинэ гэрээгээр энэхүү хэлэлцээр ба хавсаргасан протоколд заасан

зүйлүүдийг Оросын эзэн хааны Засгийн газартай урьдаар зөвлөлдөхгүйгээр зөрчих буюу өөрчилж үл болно. Дөрөвдүгээр зүйлд: Хэлэлцээр үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно гэсэн заалтууд оржээ.¹⁵

Элгэрээний хавсралт протокол нь Монгол дахь Оросын худалдааны эрхийг давуу байдлаар хуульчилж өгсөн юм. Эл гэрээгээр Оросын эдийн засгийн давуу талыг дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал, Орос улсын иргэд Монголын аль ч нутагт худалдаа эрхлэх, чөлөөтэй зорчих, үйлдвэр, үйлчилгээ гээд боломжтой бүх төрлийн бизнес явуулах, эзэмшил харгалзахгүйгээр гэрээ контракт байгуулах, гааль татваргүйгээр Монголоос бараа гадаадад гаргах, гадаадаас оруулж ирэх, хувийн өмчийг чөлөөтэй хөгжүүлэх, Оросын санхүү, зээлийн байгууллагууд өөрийн салбараа Монголд нээн ажиллуулах зэрэг эрхүүдийг оросууд дангаар эдлэх болсон юм.

Оросын бүрэн эрхт төлөөлөгч Иван Яковлевич Коростовец Хүрээнд зорчсон тухай өдрийн тэмдэглэлдээ¹⁶ болон “Чингис хаанаас Зөвлөлийн засагт Бүгд Найрамдах улс хүртэл” хэмээх номондоо Орос Монголын хооронд гэрээ хэрхэн байгуулсан тухай сонирхолтой дурсамж үлдээсэн буй. Тэрээр анх Монголын засгийн газрын ноёдуудтай уулзсан талаар өгүүлэхдээ: “Консулын газар болсон хэлэлцээрийн эхний хуралдаанд эрх баригч ноёдууд бүгд ирсэн ба тухайлбал, Сайн ноён хан, Гадаад хэргийн сайд Ханд ван, Дотоод хэргийн сайд Да лам, Сангийн яамны сайд Түшээт хан, Шүүх яамны сайд Эрдэнэ ван Намсрай, Цэргийн сайд Далай ван нар байв. 1911 онд Петербургт очсон төлөөлөгчид болох Да лам, Ханд ван нарын тухай урьд ярьсан билээ. Засагт ханыг нас барсаны дараа Сайн ноён хан саяхан сайд болсон. Ноёдууд гоёлын хүрэм өмсч, булган малгай тавьж, мориор ирцгээв. Тэдний бараа бологч олон тооны туслагчид нар хашаа үүдэнд ирцгээсэн байв.

Хуралдаанд манай талаас надаас гадна, Ерөнхий консул Люба, Попов, Эльтеков болон консулын газрын орчуулагч буриад Церемпилов нар оролцов. Дараа нь энэ буриадаас нэг бус удаа би дэмжлэг авч байв. Тэрбээр Хутагтын ордонд ойр дотно байв.¹⁷

Монголд үргэлж нөхөрсөг хандаж ирсэн Орос орон ба Цагаан хаан Хятадаас салсаны дараа учирч буй бэрхшээлийг мэдээд та бүхэнд туслахаар шийдвэрлэсэн юм хэмээн би мэдэгдэв. Хэрэв монголчууд бидэнтэй Монгол Оросын хэлхээ холбоог бэхжүүлэх, Монголд өөрийнхөө автономийн төлөө тэмцэх бололцоо олгосон тийм хэлэлцээр байгуулвал Орос орны зорилт биелэхэд хөнгөн байх болно. Бээжинд элчин сайдаар байхдаа монголын хэрэгтэй ойр танилцаж байсан болохоор намайг хэлэлцээр хийх төлөөлөгчөөр томилсон юм.

Ноёдын өмнөөс нүцгэн толгойтой (бусад нь гэзэгтэй байв), ширүүн харцтай лам Да лам үг хэлэв. Тэрбээр монголчууд Орос улстай хэлэлцээр байгуулахад бэлэн байна, гэхдээ юуны өмнө Хятадтай харилцах харилцаанд хэрхэн нөлөөлөх талаар тодруулахыг хүсэж байна. Хятадууд бас хэлэлцээр хийхийг санал болгоод буй, хэлэлцээр хийлгэхээр монгол ноён Няантыг ирүүлэхийг хүсэж

байна. Орос улсын цаашдын алхмуудыг хүлээнэж, Монголын Засгийн газар Няантыг хүлээн авахаас одоохондоо татгалзаад байгаа, Монголын Засгийн газар Гадаад Монголын нэгтгэх төдийгүй Дотоод Монголыг ч бас нэгтгэхийг эрмэлзэж байна.

Надад зөвхөн Халхын тухай л хэлэлцээр хийхийг даалгасан бөгөөд Дотоод Монголын асуудлыг одоохондоо босгон тавихгүй байсан нь дээр хэмээн би тайлбарлав. Хятадын тухайд тэдний монголчуудтай хийх хэлэлцээр бол тусгаар тогтнолыг тань солихтой адилхан болж магад. Бид хоёр талын ашиг тусын тулд монголчуудтай ойртохыг хүсэж байна. Учир нь Монгол нь буфер- улсын хувьд манай хил дээр хятадын нэвтрэн орохын эсрэг түшиг тулгуур болж болох юм хэмээн бид үзэж байгаа юм. Бидний энэ алхам нь Бээжингийн засгийн газрын үйл ажиллагаанаас үүдэлтэй бөгөөд бидний саналыг хүлээн авч ашиглах нь монголчуудаас хамаарах болно.

Дуугүй сууж байсан Сайн ноён хан хариулахдаа монголчууд бид даван туулж буй энэ үеийн чухал хэмээхийг мэдэрч байна. Таны үг болон хэлэлцээрийн төслийн талаар Богд хутагтад шууд айлтгах болно хэмээснээр бидний эхний уулзалт өндөрлөв¹⁸ хэмээсэн байна.

И.Я.Коростовец Орос Монголын гэрээ байгуулсан тэр өдөр чухам юу болсон талаар юу хэмээн тэмдэглэж үлдээсэн нэн сонирхолтой юм. Тэрбээр өгүүлэхдээ: “Аравдугаар сарын 21-нд гэрээ байгуулах явдал болов. Энэхүү түүхэн үйл явдал хэрхэн болсон талаар одоо өгүүлье. Бид тэднийг ирэхээ больсон байх хэмээн бодож байтал, ноёдууд Консулын газар үдэш орой хүрэлцэн ирцгээв. Тэдний саадсан явдал нь гарын үсэг зурах сайн өдрийг сонгосон мэргэчийн төлөг буулгасан явдал байжээ. Энэ өдөр сайн өдөр байсан тухай ноёдууд сэтгэл хангалуун надад өгүүлж байв. Бид шууд л текстийг нийлүүлэн уншиж, гарын үсэг зурах үйл явцаа эхэлцгээв. Ийм үйл явдлыг анх удаа үзэж буй монголчууд үүнд ихээхэн ач холбогдол өгч хариуцлагатайгаар хандаж байв. Тэд текстийг маш анхааралтай сонсч, өөрсдийн нэрсээ бийрээр зурахдаа маш хичээнгүйлэн хандаж байв.

Дараа нь шампанск задалж, Монголын сайн сайхны төлөө, Орос Монголын найрамдлын төлөө би хундага өргөв. Ноёдууд баярлаггааж, миний гарыг чангаар атгаж, заа хэмээн талархлаа илэрхийлж байв. Сайн ноён бүр жижигхэн үг хэлж, харин сангийн сайд Монголчууд Оросыг дайлснаас хойш энэ үйл явдал бол Монгол Оросын хооронд шууд харилцаа тогтоож буй анхны алхам хэмээн ёжлон тэмдэглэж байв. Одоо бол Монголчууд өөрийн орны хувь заяаны төлөө сэтгэл амар байж болно, учир нь Орос орон, цагаан баатар буюу цагаан хаан түүнийг хэнд өгөхгүй.

Бидний ярианы үеэр ноёдууд тэдний эргэлзээ сүүлчийн момент хүртэл үргэлжилж, харин Богд хааны өөрийнх нь шаардснаар хэлэлцээрт гарын үсэг зурахаар шийдвэрлэсэнээ хэлж байв. Учир нь саяхан Бээжингээс ирсэн Ларсоны ярианаас эргэлзээ төрж эхэлсэн байжээ. Гарал үүслээрээ норвег Ларсон нь америкийн библийн нийгэмлэгийн төлөөлөгч бөгөөд Хүрээнд нийгмийн ажлаар

ирсэн хэмээвч үнэн хэрэг дээрээ Орос улстай хийж буй хэлэлцээрийг таслахыг монголчуудад ятгахаар Бээжингийн засгийн газраас томилогдсон байв. Гэвч монголчууд түүний бүх саналыг үгүйсгэж, Орос улстай хэлэлцээр байгуулсаны дараа л Хятадтай тэгш харилцааны үндсэн дээр хэлэлцээр байгуулахад болно хэмээн мэдэгдсэн байна¹⁹ гэжээ.

Орос Монголын хооронд гэрээ байгуулсны маргааш нь Оросын консулын газар Ханд ван ирж, Хэлэлцээр байгуулсантай холбогдуулан Богд хаанаас баяр хүргэснийг уламжилсан байна. Улмаар Олноо өргөгдсөний хоёрдугаар он өвлийн тэргүүн сарын 16-ны өдөр Монгол улсын Богд хаан зарлиг буулгаж, Орос улсын хаан эзний засгийн газраас гаргасан бүрэн эрх барих сайд И.Я.Коростовецэд Чин вангийн Эрдэний Очир одон шагнаан хүртээсэн буй.²⁰

Мөн хэсэг хугацааны дараа Оросын Гадаад хэргийн яамнаас Коростовецэд цахилгаан ирсэн бөгөөд түүнд Монголын Засгийн газартай байгуулсан хэлэлцээрийн тухай Эзэн хаандаа айлтгаж, Эзэн хаан нь уг илтгэл дээр өөрийн гараар “Коростовецэд миний талархлыг илэрхийлж байна. Эзэн хааны ивээлийг хүлээн авна уу” хэмээн бичсэн байна.

1912 оны Найрамдлын гэрээ байгуулсны дараах үе

Орос Монголын хооронд Найрамдлын гэрээ байгуулснаас хойш гурав хоногийн дараа Оросын гадаад Яамны сайд Сазонов эл гэрээний талаар Хятадын засгийн газарт мэдээлэхийг албан ёсоор өөрийн элчин сайд Крупенскийд үүрэг болголоо. Эл үүргийн дагуу Бээжинд Оросын элчин Крупенский Хятадын Гадаад явдлын яамны сайдад 1912 оны 10 дугаар сарын 26-нд уламжлахад, Хятадын Гадаад яамны сайд «Орос улс Монголын засгийн газрыг хүлээн зөвшөөрчихлөө» шүү дээ «харин Дундад Иргэн улсыг хүлээн зөвшөөрөөгүй л байгаа шүү» хэмээн сануулсан байдаг.²¹ Энэ бол Орос улсын засгийн газраас Монгол улсыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр 1912 онд Найрамдлын гэрээ, худалдааны протокол байгуулсан хэмээн дэлхийн улс орнууд ойлгож байсныг илтгэж буй хэрэг юм.

Үүнээс хэдхэн хоногийн дараа Хятадын Гадаад яамны сайд Санкт Петербургт айлчилж, Оросын Гадаад яамны сайд лугаа уулзан, Хятад улс Монгол Оросын хооронд байгуулсан гэрээг хүлээн зөвшөөрөөгүй гэдгээ мэдэгдсэн байна. Үүний хариуд Сазонов тайлбарлахдаа: Орос улс Монголын тусгаар тогтнолыг бүрэн гүйцэд зөвшөөрөөгүй юм, гэхдээ бид Хятадыг гурван улсын гэрээнд оруулан хятадын сюзеренитетийг хүлээн зөвшөөрч болох юм гэж мэдэгдсэн байна.²²

Хятадын засгийн газар Хятадын нэгэн хэсэг болсон Монголтой байгуулсан аливаа гэрээг хүлээн зөвшөөрөхөөс эрс татгалзаж байгаагаар илэрхийлж, Монголын тухай аливаа асуудлаар Хятадын төв засгийн газартай гэрээ байгуулахыг сануулсан байна. Чингэхдээ Хятадын засгийн газар Оросын засгийн газраас эхлээд Монголтой байгуулсан гэрээгээ цуцлахыг шаардаад үүний дараа бид танайтай эл асуудлаар хэлэлцээр хийхэд бэлэн байх болно

хэмээн мэдэгдсэн байна. 1912 оны 11 дүгээр сарын 19-нд Хятадын сайд Санкт Петербургт Оросын гадаад яамны сайд лугаа уулзаж, Хүрээтэй байгуулсан гэрээгээ цуцлахыг бас дахин гуйсан байна. Гэвч эл бүхэнд Сазонов, Крупенский хоёул «Хятадын санал дэндүү оройтож ирлээ» хэмээн хариулсан байдаг.²³

Оросын Гадаад Яамны сайд Сазонов Монгол Оросын хооронд байгуулсан гэрээнийхээ талд ийнхүү баттай зогссон нь Оросын засгийн газар Монгол улс, түүний тусгаар тогтнолыг тодорхой хэмжээгээр дэмжсэний илэрхийлэл мөн. Нөгөө талаас, Хятадын засгийн газар удаа дараа Орос улсаас Монголтой байгуулсан гэрээгээ цуцлахыг шаардаж, гуйж байсан явдал бол Монголын тусгаар тогтнол эргэлт буцалтгүй замд орж байсныг илтгэсэн хэрэг юм. Харин Монгол Улс Орос улсын хооронд гэрээ байгуулагдсанд Хятадын Засгийн газар Гадаад яамны сайдаа буруутган албан тушаалаас нь огцруулсан билээ.

1912 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Оростой найрамдлын гэрээ байгуулснаас хойш үеийн Монгол нь бие даасан улс байсан юм, учир нь хоёр орны харилцаа Хятадаар дамжих бус шууд явагдаж байсан билээ хэмээн Волосович гэмдэглэсэн байна.²⁴ Тухайн үеийн Оросын хэвлэлүүд энэхүү гэрээ бол улс биш байсан бол байгуулагдахгүй байсан, нэгэнт байгуулагдсан болохоор Монголыг сюзеренитет болгохын эсрэг байгуулсан гэрээ болж таарна хэмээн бичиж байжээ. Түүгээр ч үл барам 1912 оны Орос Монголын хооронд байгуулсан гэрээгээр Монгол улсын нэрийг Гадаад Монгол гэж бус Монгол хэмээн бичиж байхаар Орос улс баталгаажуулсан юм хэмээн Петер Тан бичжээ.²⁵ Харин газар нутгийн тухайд ямар нэгэн зүйл эл гэрээнд тусгагдаагүй юм хэмээн тэрээр бичжээ.

Орос Монголын хооронд байгуулсан гэрээг гадаадын ажиглагчид янз бүрээр тайлбарлаж байсан байна. «Орос улс ийнхүү гэрээ байгуулснаар шинэ улс байгуулагдахад тус дэм боллоо» гэх буюу эсвэл «Монгол нь Хятадаас салан тусгаарлаж эрх чөлөөтэй болсноор Оросын колони болчихгүй» хэмээн бичиж байжээ.²⁶

Оросын эзэнт гүрэн Богд хаант Монгол улс хоёр хоорондоо Гэрээ байгуулж, баримт бичгүүд солилцсоноор Монголд эзлэх Оросын нөлөө ихсэх болсон нь Орос, Дундад Иргэн улсын хүчний харьцаанд урьд байснаас нилээд өөрчлөлт орж, улмаар хоёр тал монголын асуудлаар хэлэлцээр хийх хэмжээний асуудал болсон байна. Энэ нь хятадууд Монголыг урьдын адил дангаар эзэрхэх гэсэн Хятадын байр сууринаас хальж, Монголын асуудлыг Оростой ярилцах болсон нь монголчуудын хувьд багагүй дэвшил болсон хэмээн үзүүштэй. Нөгөө талаар Орос Монголыг хэлэлцээр хийх эрх бүхий этгээд хэмээн үзсэн нь Монгол өөрийн тусгаар тогтнолын төлөө асуудалдаа өөрийн саналаа оруулж, түүнийхээ төлөө тэмцэх боломжоор хангагдаж эхэлсэн ололт байлаа. Энэ бол Богд хаант Монголын улсын төрийн удирдагчдын асар их ухаан, хүчин чармайлтын үр дүн хэмээн үзмээр санагдана.

Орос улс Орос-Монголын 1912 оны гэрээгээр олж авсан өөрийн давуу талуудыг хэвээр хадгалах нөхцөлд Монголын асуудлаар Хятадтай тохиролцоход

бэлэн байсан билээ. Орос Монголын найрамдлын гэрээнд 1912 оны 11 дүгээр сарын 3-нд Хүрээнд гарын үсэг зурсаны дараахан энэхүү баримт бичгийн тухай Оросын Гадаад Явдлын яамнаас Англи, Франц, Япон зэрэг орнуудын элчин сайд нарт албан ёсоор мэдээлэл хийж тайлбарлахдаа, сайд Сазонов: “Хэрэв Хятад улс энэ гэрээний зарчмуудыг хүлээн зөвшөөрвөл түүний зүгээс Монголтой ямар нэгэн гэрээ хэлэлцээр байгуулж Монголд эзэн эрх (сюзеренитэт) тогтооход татгалзахгүй”²⁷ гэсэн нь Оросын байр суурийг тодорхой илэрхийлсэн хэрэг байлаа.

Хэдийгээр хятадууд Орос-Монголын 1912 оны найрамдлын гэрээ бичиг болон, харилцан солилцсон бусад баримт бичгүүдийг хууль бус зүйл хэмээн эсэргүүцэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байсан хэдий ч Оросууд энэ талаарх өөрийн байр суурийг ягштал баримталж байлаа. Иймээс ч Бээжин дэх Оросын төлөөлөгч Засгийн газрынхаа нэрийн өмнөөс Дундад Улсын Гадаад Явдлын Яамны сайдтай уулзаж, Орос, Монголын хооронд байгуулсан найрамдлын гэрээ болон бусад баримт бичгийн талаар танилцуулж, Орос улсын зүгээс Хүрээний засгийн газрын өмнө хүлээсэн үүргийг сануулж, эдгээр баримт бичгийг ДИУ-аас хүлээн зөвшөөрөхийг шаардсан байна. Чингээд зогссонгүй Оросын зөвлөх Хятадын гадаад явдлын яаманд очиж, 1912 оны 11 дүгээр сард Монголын тал элчингээ томилон Оросын нийслэл - Петербург хотод явуулсан хэмээн худал мэдээлэл хийж байсан нь оросууд Монгол дахь өөрийн ашиг сонирхолыг алдахыг хүсэхгүй, улмаар бэхжүүлж, Хятадаар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд тэдэнд шахалт үзүүлсэн хэлбэр байв.

Ийнхүү орос, хятадууд өөр хоорондоо хэд хэдэн удаа ноот солилцож, өөр өөрсдийн байр суурийг илэрхийлсэний эцэст Монголын асуудлаар хэлэлцээр хийхээр харилцан тохиролцжээ.

Орос Монголын 1912 оны гэрээ болон түүний хавсралт Оросын худалдааны эрхийг баталгаажуулсан 17 заалт бүхий протоколыг эсэргүүцэж байсан хэдий ч Монголын асуудлыг Оростой тохиролцох үүднээс Хятадын засгийн газар эцэст нь тэрхүү Монгол Оросын хооронд байгуулсан худалдааны протоколыг хүлээн зөвшөөрсөн юм. Албан ёсоор 1913 оны Орос Хятадын тунхагийн дөрөвдүгээр заалтад энэ тухай өгүүлсэн байдаг. Мөн түүнчлэн 1915 оны Хятад, Орос, Монгол гурван улсын гэрээний 21 дүгээр зүйлд эл асуудлыг баталгаажуулсан юм. Энэ нь 1912 оны Орос Монголын хооронд байгуулсан гэрээ, худалдааны протокол хүчин төгөлдөр болохыг тодорхойлсон хэрэг билээ.

Энэхүү найрамдлын гэрээ нь ямар нэгэн зөрчилгүй явагдсан хэмээн үзвэл бодит байдлаас ташаа болох билээ. Оросын талын санал болгосон гэрээний төсөлд «Гадаад Монгол» хэмээн бичигдсэн байсан бөгөөд Монголын тал үүнийг эс зөвшөөрч, эсэргүүцсэн тул «Монгол» хэмээх нэрийг хэрэглэхээр тогтжээ. Чингэхдээ «Монгол» хэмээх нэр нь улсын нэр байж болох ба бас газар нутгийн нэр зааж болох хоёрдмол утгатайгаас гадна Ар Монголыг буюу эсвэл нийт Монгол үндэстнийг хамруулан хэрэглэсэн ойлголт болж болох салаа утгаар уг гэрээний

орос эхэнд хэрэглэгдсэн байдаг.²⁸

Энэ тохиролцсон ёсоор гэрээний монгол эхэнд «улс» гэдэг үг нэмэн «Монгол улс» гэж хэрэглэсэн байдаг билээ. Энэ нь Богд тэргүүтэй Монголын төрийн удирдагчид тулгур байгуулагдсан төр нь бусад улс гүрнүүдийн нэгэн адил эрх бүхий бие даасан улс болохыг харуулахын зэрэгцээ Ар Монголын төдий бус нийт монгол үндэстний гал голомт болсон улс гэсэн санаагаар ойлгож, ийм бодлогыг хэрэгжүүлэхийг хичээж байсны илрэл юм. Мөн түүнчлэн «Монголын засгийн газар» хэмээх нэрийг хэрэглэснээс гадна хоёр гэрээ байгуулагч этгээд хоёр улсын засгийн газрыг харилцан хүлээн зөвшөөрсөн явдал монголчуудын хувьд үнэхээр онцгой ач холбогдолтой байсан юм. Мөн гэрээ байгуулах үеэр Монгол улсын эдлэх эрх хэмжээний тухай асуудал санал зөрөлдсөн асуудлуудын тоонд орж байв. Гэрээний орос эхэнд Оросын тал нэгэнт тогтсон автономит байгууллыг хамгаалахад Оросын эзэн хааны засгийн газар туслах болно гэсэн ахул, монгол эхэнд автономит байгуулал хэмээх үгийг хэрэглэхгүйгээр тусгаар тогтнол гэсэн утгаар ойлгох үг хэрэглэн: «Их Орос улсын эзэн хааны засгийн газраас Монгол улсыг өөртөө тогтнож өөрөө эзэрхэх ёс журам сахихад тусламуй» гэжээ.²⁹

Мөн 1912 оны гэрээ Монголд өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэн цэцэглүүлэх бүрэн эрх чөлөөг оросуудад олгосон юм, чингэснээр «Монголыг бүхий л чиглэлээр онгичиж, дарангуйлахад» хүргэсэн юм хэмээн эрдэмтэн Е.М.Даревская бичжээ. Оросын засгийн газрын дэмжлэгийг албан ёсоор хүлээсэн худалдаа, арилжааныхан алт мөнгө гээд бүхий л бололцоотой бүх ашигт малтмалыг эрж хайх олборлох «Нийгэмлэг», «Нөхөрлөл»-ийг олноор нь Монголд байгуулж, Монгол руу улсын болон хувийн бүхий л барааг оруулан худалдаалж байжээ. Монголын үндэсний банк хүртэл байгуулсан нь буй ажээ. Оросын рубль хятадын мөнгийг бага багаар шахаж эхлэх болжээ.³⁰ Монгол дахь Оросын худалдаа тооны хувьд өсөхийн хэрээр чанарын хувьд ч мөн өсөж байв.

Ийнхүү оросууд Монголыг эдийн засгийн хувьд эзлэн түрэмгийлж эхэлсэн энэ үеийг Оросын төрөөс Монголын талаар явуулсан бодлогын хэрэгжилт хэмээн үзүүштэй юм. Мэдээж энэ бүхэнд хил залгаа байдал, удаан жилийн түүхийн улбаа, уламжлал, эдийн засгийн харилцан сонирхол зэрэг нь Орос гүрний зүгээс Монголын талаар түүхийн удаан хугацааны турш тодорхой бодлого баримтлахад хүргэсэн бөгөөд 1911 оны дараа Орос улс бусад их гүрнээс өрсөж, өөрийн боломжийг ашиглан Монголд ашиг сонирхлоо өргөтгөх нь стратегийн хувьд ч чухал байсан юм. Орос Японы гэрээ ёсоор олж авсан өөрийн нөлөөний бүсээ хэн нэгэнд алдах, хэн нэгэнтэй хуваалцах сонирхол Оросын төрийн эрх баригчдад байгаагүй юм.

1912 онд Орос Монголын хооронд байгуулагдсан эл гэрээ Монголын олон улсын талбар дээр дахин төр улс болж гарч ирсэний нэгэн илэрхийлэл болсон юм.

И.Я.Коростовецийн гарын үсэг зурсан 1912 оны Монгол- Орос хоёр орны гэрээний учир холбогдлыг Оросын дипломатч Барон Нольде ихэд үнэлж,

1930 онд ийн бичжээ: “Монгол улсыг байгуулсан нь Оросын эзэнт гүрний дипломат бодлогын томоохон амжилтуудын нэг юм... Энэ сургуулийн тэргүүн эгнээнд дайны өмнө И.Я.Коростовец болон Алс Дорнодын хэлтсийн дарга асан, талийгаач Г.А.Казаков нар зогсож байлаа. Тэрхүү томоохон түүхэн үйл хэргийг хэрэгжүүлэх нэр төр тэдэнд хамтад нь ногдсон байв... Монгол улс бүрэлдэн бий болоход И.Я.Коростовецийн гэрээ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн билээ”.

Чухамдаа XX зууны эхээр Монгол улс сэргэн мандах үйл явцын эхний шатанд И.Я.Коростовец Монгол улсын төлөө үнэхээр үлэмж ихийг хийсэн агаад миний бодоход монголчууд В.И.Лениний үйл хэрэг гэхээсээ илүү И.Я.Коростовецийн үйл хэргийг Монголын түүх, Монгол, Оросын харилцааны түүхэнд илүү тусгавал зохистой юм. Энэ нь түүхийн өмнө илүү шударга хэрэг болохсон.

И.Я.Коростовец Оросын эзэнт гүрний ашиг сонирхлыг төлөөлж байсан нь эргэлзээгүй боловч Монгол улсын бие даасан байдлыг сахин хамгаалах, улам боловсронгуй болгоход дээрх ашиг сонирхол асар их үүрэг гүйцэтгэсэн болно. Судлаач Ж.Фритерс И.Коростовецийн талаар өөрийн гэсэн дүгнэлт хийн: “Энэ хүн бол Оросын эзэнт улсын хамгийн чадварлаг дипломатуудын нэг бөгөөд Гадаад Монголд Оросын бодлогыг идэвхтэй хэрэгжүүлэх үйл хэргийн судсыг гартаа барьж байсан билээ” хэмээн бичсэн байдаг нь тун онож дүгнэсэн хэмээн үзүүштэй

Хятадад олон жил алба хаах хугацаандаа түүний олж авсан дипломатчийн асар баян туршлагыг нь Дмитрий Абрикосов онцгойлон тэмдэглэж: “Элчин (И.Коростовецийг хэлж байна – О.Б.) их онцгой хүн бөгөөд алмаз эрдэнэ мэт чухаг, эрхэм нэр хүндтэй болой” гэжээ. Энэ үг хүнийхээ хувьд тэрээр хэн байсныг тод харуулж буй юм.

И.Я.Коростовец 1912 онд Орос-Монголын Найрамдлын гэрээ байгуулахыг санаачлагчдын нэг мөн гэдэг нь эргэлзээгүйгээс гадна XX зуунд Орос-Монголын харилцааг бэхжүүлэх, цааш хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан гарамгай дипломатч хэмээн бид үзэж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү гэрээ байгуулагдсан нь монгол хятадын хооронд явж ирсэн урьдын харилцааг тодорхой хэмжээгээр сулруулж, монголчуудын эдийн засаг, амьдралд оросын оролцоог нэмэгдүүлэх боломж нээсэн билээ.

Хэдийгээр 1912 оны Монгол Оросын найрамдлын гэрээ, худалдааны протоколыг эдийн засгийн асуудлыг голлон шийдвэрлэхэд чиглэсэн хэмээн тодорхойлдог боловч эл гэрээ Монголын хувьд улс төрийн онцгой ач холбогдол агуулсан юм. Орос Монголын хооронд ийм гэрээ байгуулагдсан явдал нь өөрөө монгол хятадын хооронд тогтсон байсан урьдын харилцаа ул болж, түүнд цэг тавьсан төдийгүй, Шинэ Монгол улс дэлхийн аль ч улс оронтой эн тэгш харилцах боломж нээж өгсөн юм.³¹

Энэ гэрээ нь Монгол улс тусгаар тогтнолоо тунхаглан зарласнаас хойш Монгол улсын олон улсын харилцаанд эзлэх статусыг тодорхойлоход хууль эрхийн анхны бодитой баримт бичиг болсон юм. Энэ гэрээгээр:

1. Монгол бол эзэн хаантай, Засгийн газартай улс мөн,
2. Монгол нь өөрийн улсын цэрэг байгуулах эрхтэй,
3. Монгол нь «өөртөө тогтнож, өөрөө эзэрхэх» ёс журамтай,
4. Монгол нь өөрийн нутгаас Хятадын цэрэг ба эрх баригчдыг үлдэн гаргасан бөгөөд дахин өөрийн газарт Хятадын цэрэг ба нүүдлийн иргэдийг үл оруулах эрхтэй,

Монгол нь Хятад болон бусад гадаад улстай хэлэлцээ хийж өөр гэрээ байгуулах эрх бүхий этгээд мөн гэдгийг Орос улсын Засгийн газар хүлээн зөвшөөрч эдгээрийг «алдагдалгүй сахихад» цөм тусална гэж Орос улс өөртөө үүрэг авсан байлаа. Гэрээ нь тухайн тодорхой нөхцөлд Монголд нилээд дэвшилттэй алхам болсоныг тэмдэглэх учиртай. Эл хэлэлцээрээр монголчуудын санал болгосон Өвөр Монгол, Баргыг Монголд дагаар орох асуудлыг хэлэлцэхээс оросууд эрс татгалзаж, Петербурgt Монголын элчин суулгах тухай асуудал мөн татгалзсан хариу авчээ. Өвөр Монголын асуудал нь урьд нь Орос Японы хооронд байгуулсан нууц гэрээгээр нэгэнт шийдэгдсэн байсан бол Оросын нийслэлд Монголын элчин нээх асуудал нь Орос улс нэгэнт Монголын тусгаар тогтнох эрхийг Хятадын харьяаны автономиор хязгаарлах бодолтой байсан учраас татгалзсан санал авсан байна.

Орос улс энэ 1912 оны найрамдлын гэрээгээр Монголын засгийн газрыг, Монголын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээсэн бөгөөд ийм ч учраас Монголыг гэрээ байгуулах эрхтэй хууль ёсны субъект хэмээн үзсэн хэрэг юм. Орос Монголын хооронд байгуулсан эл гэрээ дэлхий нийтэд зарлагдсан явдал өөрөө Монгол улсын нэрийг «Монгол» хэмээн хүлээн зөвшөөрч тунхагласнаас ялгаагүй хэрэг байлаа. Үүнд мэдээж хятадууд дуртай байгаагүй юм. Ийнхүү дэлхий нийтээр Монгол улс тухайн үед хүчирхэг Оросын эзэнт улстай гэрээ байгуулсан нь Монголынхоо тусгаар тогтнолын төлөө тэмцлээ үргэлжлүүлэн явуулахад ихээхэн дөхөм үзүүлсэн явдал байлаа.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ Үндэсний төв архив ф.4, д.1, х.н.136

² Н.Магсаржав Монгол Улсын шинэ түүх, УБ., Сүхбаатар хэвлэх үйлдвэр, 1994, 12 дахь тал

³ Н.Магсаржав Монгол Улсын шинэ түүх, УБ., Сүхбаатар хэвлэх үйлдвэр, 1994, 12 дахь тал

⁴ О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: Амьдрал ба домог, УБ., 2011 он

⁵ И.Майский Современная Монголия Ир., 1921г, с.330-331

⁶ Белов Е.А. Как возникли тройственные русско-китайско-монгольские переговоры в Кяхте в 1914 г. Китайская традиционная культура и проблемы

модернизации Часть 1, М.,1994.,с.176

⁷ Международные отношения в эпоху империализма Документы из архивов царского и временного правительств (1878-1917) М-Л.1931, серия 2, т.20, ч.2,с.7

⁸ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл Баримт бичгийн эмхтгэл., 1900-1914. УБ.,1982, 170 дахь тал

⁹ Сборник дипломатических документов по Монгольскому вопросу Спб.1914.,с.1-2,

¹⁰ Сборник дипломатических документов по монгольскому вопросу. СпБ, 1914, с.1

¹¹ (Э.Д.Гримм Сборник документов по монгольскому вопросу ...т.169,180)

¹² Мөн тэнд

¹³ “Международные отношения...., сер. 2, т.18., часть 1., с. 227

¹⁴ Л.Жамсран Диссертаци., х.82

¹⁵ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл Баримт бичгийн эмхтгэл . 1900-1914, УБ.,1982он, 174-175 дах тал, Гримм Э. Сборник договоров и других документов по истории международных отношений на Дальнем Востоке (1842-1925) М.,1925он, с.181-183

¹⁶ И.Я.Коростовец Монголд өнгөрүүлсэн есөн сар Монгол дахь Оросын Бүрэн эрхт төлөөлөгчийн өдрийн тэмдэглэл 1912 оны 8 сараас 1913 оны 5 сар, Эмхтгэгч О.Батсайхан, Хянан боловсруулсан О.Батсайхан, О.Бакич, Наками Татсуо, УБ.,2010 он

¹⁷ И.Я.Коростовец От Чингис хана До Советской республики УБ., 2004 г. С.211

¹⁸ И.Я.Коростовец От Чингис хана До Советской республики УБ., 2004 г. С.212

¹⁹ И.Я.Коростовец От Чингис хана До Советской республики УБ., 2004 г. С.234-235

²⁰ Үндэсний төв архив ф.А3, т.1, х.н.27, х.1-5

(Сборник дипломатических документов по Мон. Вопросу 23 авг. 1912г – 2 нояб.1913г. С.Петербург, 1914, с.32)

²¹ Peter S.H. Tang Russian and Soviet policy in Manchuria and outer Mongolia 1911- 1931 Duke university press Durham, North Carolina, 1959 p.314

²² Мөн тэнд p.315

²³ М.Волосович Россия и Монголия – Вестник Азии Ио 31-32, 1914, с.42

²⁴ Peter S.H. Tang Russian and Soviet policy in Manchuria and outer Mongolia 1911- 1931 Duke university press Durham, North Carolina, 1959 p.313

²⁵ Peter S.H. Tang Russian and Soviet policy in Manchuria and outer Mongolia 1911- 1931 Duke university press Durham, North Carolina, 1959 p.316

²⁶ Б.Санжмятав Гурван улсын Хиагтын гэрээний тухай түүхэн үнэн., УБ., 1991., 7 дахь тал

²⁷ Сборник договоров России с другими государствами 1856-1917 , М, 1952., с.411

²⁸ Үндэсний төв архив ф.1, д.1, х.н.74

²⁹ Н.Е.Единархова Русские в Монголии: Основные этапы и направления деятельности в 1861 –1919 гг. - Материалы конференции «Россия и Монголия в многополярном мире» \Часть 1, вып 2, Иркутск., 2000., с.62

³⁰ О.Батсайхан Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (1911 -1916) УБ., 2002 он, 259 дэх тал

³¹ Үндэсний төв архив, ф. А4. Т.1.х.н. 656